



Published in the Russian Federation
Bulletin of the Kalmyk Institute for Humanities
of the Russian Academy of Sciences
Has been issued since 2008
ISSN: 2075-7794; E-ISSN: 2410-7670
Vol. 26, Is. 4, pp. 154–159, 2016
DOI 10.22162/2075-7794-2016-26-4-154-159
Journal homepage: <http://kigiran.com/pubs/vestnik>

UDC 821.512.36

The Influence and Contribution of the Novel *Tungalag Tamir* to Inner Mongolian Literature

Khishigdelgeriin Khohmandal ¹

¹ Postgraduate Student, School of Arts and Sciences, National University of Mongolia (Ulan-Bator, Mongolia). E-mail: 920321387@qq.com.

Abstract

The famous writer from the Mongolian People's Republic Lodoidamba Ch. finished his novel *Tungalag Tamir* in 1971 and soon received a government award. The novel accurately depicted the early 1930s and actual situation, social conditions, relations with authorities and even the outer world of the Mongols who lived by the river called *Tungalag Tamir*.

He begins the novel with the words: "One day in early summer which is ...". This suggests that the narration starts from 1914. In the end he writes: "In the autumn of 1932 ...". Thus, those are experiences of this period that were described in the novel. The composition was affected by the theory of Socialist reality, so the writing techniques make its characters look realistic enough.

The novel *Tungalag Tamir* can be divided into several parts depending on time periods. From 1914 through 1921, the Mongolian people were under the reign of the diverse political and military alliances, namely the 'black' ones, 'yellow' feudal ones and those fighting for democratic values. Between 1921 and 1932, the Mongolian people chose to become independent from capitalists and established a Socialist society. The writer describes the historical events and creates approximately 130 characters — with definite distinguishing features — which are independent personalities with their own destinies; the proof of this can be found in the end of the very novel: "The images, thoughts and even destinies of the three generations were unfolded before the reader's eyes". During the lifetime of the first generation, people suffer from social bondages and rely on Buddhism, they completely — and even irrationally — trust in religion. They are convinced regarding their miserable fates and take sufferings for granted. Those characters include Doljin, Hishigt, Nym, Galsan and others. Characters of the second generation see their fight as a duty rather than retribution of an evil for evil, perceive work as a means to attain happiness rather than a torment and are awoken from the old heresy and search for a totally new way to live the life they long for; those are Janjin, Cuhbaatar and Erdene, Xvyg, Dorj, Dolmaa, etc. The third generation is represented by those who inherited the revolutionary missions from their fathers and advocate the methods of science that can and shall change the old and laggard life of the community. Those are Bat, Jargal, Colongo, etc. In view of the aforesaid, due to the novel we have an opportunity to witness the experiences of those harsh times — the fight of the Mongolian people against the feudal forces — and appreciate the influence of the October Revolution on the new destiny of Mongols. In terms of cultural exchange, the novel *Tungalag Tamir* had a significant influence not only on the Inner Mongolian people and literature but also on the ethnic Chinese of Inner Mongolia. And the two editions (i. e. both Mongolian and Chinese ones) of the novel contributed a lot to cultural communication between Chinese and Mongolian individuals. In those days, the novel *Tungalag Tamir* revealed the Mongolian society, Mongolian traditional life style, even the very nomadic culture to all its numerous readers.

Keywords: novel *Tungalag tamir*, Inner Mongolian literature, status.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын (тухайн үеийн нэрээр) нэрт зохиолч Ч. Лодойдамба 1971 онд төрийн шагнал хүртсэн «Тунгалаг Тамир» гэдэг түүхэн романдаа Тамирын голын сав нутагт өрнөж байгаа үйл явцаар жишээ болгож, хорьдугаар зууны эхний гучаад жилийн Монголын ард түмний амьдрал тэмцэл, нийгмийн байдал, улс төр, гадаад байдал гэхчлэн олон талын хүчин зүйлийг өргөнөөр багтаан, оновчтой дүрслэн харуулжээ [Лодойдамба 1999: 5]. Зохиолын эхэнд «олноо өргөгдсөний дөрөвдүгээроны зуны эхэн сарын нэгэн өдөр» [Лодойдамба 1971: 1] хэмээсэн нь 1914 оныг тэмдэглэж буй хэрэг бөгөөд зохиолын төгсгөлд тэмдэглэгдсэн «мянга есөн зуун гучин хоёр оны намар» [Лодойдамба 1971: 448] хүртлэх бараг хорь шахам жилийн хугацаанд өрнөсөн түүхэн үйл явдлыг уран зохиолын хэлбэрт системжүүлэн, XX зууны урлагийн үзэл санаанд гүнзгий хувь нэмрээ оруулсан социалист реализмын онол, арга зүйн үүднээс түүхэнд үүссэн бодит үнэн явдлаас үүсэж бүтсэн үнэн бодит дүр төрхийг уран зохиолын багарт амилуулан зохиомжилжээ.

«Тунгалаг Тамир» романд бичигдсэн хорь шахам жилийг тухайн түүхэн нөхцөл байдалтай холбогдуулан юуны өмнө нэгдүгээрт, 1914 оноос 1921 он хүртлэх цаг хугацааг гадаад, дотоодын хар шар феодалын эзэрхэг ноёрхолтой тэмцэн ардын хувьсгалаар байгуулагдсан үндсэн хуульт эзэнт төрийн эрхийг тогтоосон цаг үе, хоёрдугаарт, 1921 оноос 1932 он хүртлэх цаг хугацааг хөрөнгөтнийг түшиглэхгүйгээр хөгжлийн замыг эрэлхийлж, хөрөнгөт ёсыг алгасан нийгэм журмын замыг хайж, нийгэм журмаар улс төр барихыг ухуулсан цаг үе гэж бүдүүвчлэн хувааж болно [Ван Мин 2010: 1]. Яг энэхүү цаг хугацааны учрыг зохиогч бүтээлдээ дүрслэгдсэн нэг зуун гучаад баатрын харилцан адилгүй зан төрх, хувь заяаг өгүүлэх замаар дэлгэн үзүүлэв. Үүнийгээ тус романы төгсгөлийн үгэнд «гурван үеийн хүний шинж төрх, үзэл санаа, хувь заяаг дурайлган харуулж байна» [Лодойдамба 1971: 453] гэж товчлон өгүүлжээ.

Энд өгүүлж бүхий нэгдүгээр үеийнхэн гэдэгт хамжлагат нийгмийн харанхуй ёс, бурхан шашны бурангуй номлолд доройтон мансуурч, мухар сүсэгт мунхран, амьдралын сайн сайхныг хойт насандаа даатган залбирч, энэ төрлийнхөө зовлон зүдгүүр, уй гашууг хүлцэн наманчилж яваа

Должин, Хишигт, Ням, Галсан нарын дүр, хоёрдугаар үе гэдэгт тэмцэл бол нүгэл биш буян, хөдөлмөр бол там биш жаргал мөн гэсэн хувьсгалын бүрэн дуугаар олон зуун жилийн шарын шашин, мухар бишрэлийн амтат зүүднээс сэрж, жанжин Сүхбаатар тэргүүтэй хувьсгалын удирдагчдын зарлиг тушаалаар итгэл зориг, эв нэгдлээ болгосон Эрдэнэ, Хуяг, Дорж, Дулмаа нарын дүр, гуравдугаар үе гэдэгт хувьсгалын хэргийг залгамжлан авч, гүнзгийрүүлэн шинэ нийгмийг цогцлон байгуулах шинжлэх ухаан, шинэ цагийн төрөлжсөн мэргэжлээр улс гэр, нийгэм, хүн ардын амьдралын хувь заяаг аварч өөрчлөхийг түүхийн явцаар хүлээхийн хамт үүргээ гүнзгий мэдэрч байгаа Бат, Жаргал, Солонго нарын дүр нэгд нэгэнгүй илэрхийлэгдэн бүтээгджээ [Мандал 1988 : 24].

Үүнээс бид тус романд Монгол улсын ард түмний феодал хүчний эсрэг эрс тэмцэл явуулж, Орос улсын арван сарын (октябрийн) хувьсгалын нөлөөгөөр эрх чөлөөт тусгаар тогтнолоо сэргээж, туурга тусгаар бүгд найрамдах улс болсноо тунхаглахаар тэмцсэн бүх явцыг багтаан бичсэнийг мэдэж болно.

Дээр өгүүлсэн ёсоор «Тунгалаг Тамир» романд амилан бүтээгдсэн зохиолын гол дүрүүд бүгд гурван үеийн хориод хүний дүр байдаг. Зохиогчоос эдгээр олон харилцан адилгүй дүр төрхийг бүтээхээр дамжуулан тухайн үеийн цаг төрийн байдал, нийгмийн тэмцэл, ард түмний амьдралын түүхийг тодруулан өгүүлж, Монгол улсын нийгмийн зөрчил мөргөлдөөн хурц ширүүн байсан цаг үед амьдарч асан янз бүрийн давхаргын хүн ардын сэтгэлгээний хувиралт, түүний дотроос хатуу чанга тэмцлийн дүр зургийг дэлгэн илчилжээ.

Энэхүү «аварга» бүтээл нь хэл, соёлын талаар судалгааны чухал ач холбогдолтойгоор үл барам Монгол үндэстний түүхийн судалгааны хувьд ч ашиглаж болмоор тун чухал ач холбогдолтой болохыг тэмдэглэх нь зүйтэй юм. Тийм болохоор энэ романыг «XX зууны шилдэг монгол роман» мөн хэмээн монголын уран зохиол судлаач эрдэмтэд дуу нэгтэйгээр хүлээн зөвшөөрчээ.

1977 онд босоо монгол бичгээр хөрвүүлэгдэн Өвөрмонголын олон түмэн уншигчийн оюуны хүртээл болж чаджээ. Босоо монгол үсгээр анх удаа хэвлэгдсэнээс хойш энэхүү роман зургаан удаа хэвлэгджээ [Хосбаяр 2007: 23]. Хэдийгээр хэвлэгдэх

удаа бүрийн хэвлэгдсэн тоо нь харилцан адилгүй боловч тухайн хэвлэлт болгондоо уншигчдын захиалгын тоонд тулгуурлаж гаргасан төлөвлөгөө ёсоор хэвлэгдсэн учраас тэр даруйдаа тархагдан дуусчихдаг. Юуны урьд энэхүү тооны бүртгэлээс авч үзвэл «Тунгалаг Тамир» роман нь Өвөрмонголын уншигчдын сэтгэл зүрхэнд гүн хоногшиж, нэгэн үе «Тунгалаг Тамир»-ын «халуурал» болох хэмжээнд нэгэнт хүрч байсныг тэмдэглүүштэй. Энэхүү сонирхолтой үйл явцын хүрээнд «Засагт ханы цахиур Төмөр», «Эр хүн эр хүндээ хайртай», «Баян Итгэлтийн хүү Хонгор» гэхчлэн зохиолын баатрын нэрсийг нь орлуулан өөрийгөө өгүүлж, түүх соёл, баатар эрс, адуу малаараа бахархсан хүмүүс болцгоохын зэрэгцээ Өвөрмонголын уран зохиолд «Тунгалаг Тамир» гэх романыг бат бэх байр суурьтай болгон бэхэлжээ. Нэн онцгойлон «цахиур» Төмөрийн зүгээс Итгэлтийн хүү Хонгорт хэлсэн «эр хүн эр хүндээ хайртай» [Лодойдамба 1971: 10] гэх үг уншигчдын сэтгэл зүрхэнд гүн сэтгэгдэл төрүүлж, ид хүч, сэтгэл итгэлийн тэнхээ авч буй мэт амнаас ам дамжин яригдаж, бичгээс бичиг дамжин бичигдэх болжээ.

«Тунгалаг Тамир» түүхэн роман Өвөрмонголд босоо монгол бичгээр хэвлэгдэн тархагдасны дараагаар Өвөрмонголын уран зохиолын яс чанар, нэн онцгойлон романы бичлэгийн арга хэлбэр, үзэл бодлоо илтгэх арга зарчмын хувьд мэдэгдэхүйц хувиралт гарсаныг утга зохиолын түүхийн судалгаа баттай гэрчилж чадна.

Соёлын хувьсгалын үед соёл түүх, язгуур урлаг, уламжлалт амьдралын үзэл бодлоо хэрэглэж үл болох дарамтад дарлагдаад дөнгөж сая эрх чөлөөгөө олж байсан Өвөрмонголчуудад «Тунгалаг Тамир»-ын бичлэгийн хэлбэр, жич бичлэгийн үзэл санаа нь Өвөрмонголын зохиолчдын үзэл бодлыг түргэн чөлөөлж, сэтгэхүй урлагийг нь баяжуулж, амьдрал, улс төр, нийгмийн шахалтад өртөлгүй чөлөөтэй сэтгэн бодолхийлж зохиол бүтээлээ системтэй туурвих замыг зохих хэмжээнд нэмэгдүүлжээ. «Тунгалаг Тамир» роман нь Монгол улсад дөрвөн ангит кино болгон найруулагдаж [Вен Ин 2013: 43], «Тунгалаг Тамир» хэмээх романыхаа нэртэй ижил нэртэйгээр урлагийн байгууллагуудын тогтолцоогоор дамжин цацагдсан нь Өвөрмонгол уншигчдын хүсэл сонирхлыг татаж, киног нь ахин дахин үзэхийн хамт түг

түмэн уншигчдыг дахин нэг удаа «Тунгалаг Тамир» романыг сонирхон уншихад хүргэжээ. Иймээс «Тунгалаг Тамир» романы Өвөрмонгол уншигчдын оюуны эрэлт хэрэгцээг хангаж, хүсэл сонирхлыг татсан, жич эрдэмтэн судлаачдын судалгааны үр дүнгүүдээс ч харсан, аль эсхүл «Тунгалаг Тамир» киноны урлагийн үнэ цэнэ, үүрэг, ач холбогдлоос ч дүгнэн үзэхэд, «Тунгалаг Тамир» роман нь Өвөрмонголын уран зохиолд багагүй хэмжээний түлхэц үзүүлж, Өвөрмонголын романы туурвилтыг шинэ шатанд гарахад ихээхэн нөлөө үзүүлсэн гэж хэлж болох юм.

Монгол улсын орчин уран зохиолын шилдэг бүтээлүүд нь анх хорьдугаар зууны тавиад оноос эхлэн Хятад хэлнээ орчуулагдаж эхэлжээ. Ингээд 1955–1965 оны хоорондох охорхон арван жилийн хооронд роман, жүжиг, яруу найргийг багтаасан нийт 20-иод бүтээл хэвлэгдсэнээр Монгол улсын уран зохиолын Хятад орчуулгын оргил үеийг бий болгожээ [Вен Ин 2005: 5]. Алдарт орчуулагч Вен Жүн Ге «Тунгалаг Тамир» романыг 1984 онд хятад хэлэнд орчуулжээ. Хятад хэлэнд орчуулагдсан «Тунгалаг Тамир» роман нь Өвөрмонголын ардын хэвлэлийн хорооноос хэвлүүлэн тараагдаж, тоо хэмжээний хувьд 8700 иж бүрэн ботид хүрсэн байна [Вен Ин 2013: 43].

Хэдийчинээ олон үндэстний хүртээл болох тусам төдий чинээ дэлхийн хэмжээнд хүрдэг нь илэрхий зүйл. Яг энэ үүднээс үзвэл, «Тунгалаг Тамир» роман нь монгол үндэстний жирийн байгаль орчин, нутаг усанд ердийн байдлаар өрнөж байгаа уламжлалт нүүдлийн соёлд суурилсан учраас Монголчуудын ажил амьдралдаа зохицуулан бүтээсэн зан үйлийн ариун дээд ёс суртахууныг илэрхийлэн харуулж, тухайн цаг үеийн нийгмийн амьдралыг хүүрнэн өгүүлсэн учраас Монгол соёлын агуулгаар туйлын баялаг байдаг. Тэр тусмаа «Тунгалаг Тамир» романд маш олон ардын дуу, зүйр үг, хэлц үг, үлгэр домог зэргээс гадна Монгол үндэстний уламжлалт зан үйлийн ёс горим, эмх цэгцийг бодит амьдралд уялдуулан дараалуулж уран яруугаар хүүрнэжээ.

Тухайлбал, «Цахиур» Төмөрийн цаг үргэлжид дуулж, морины нуруун дээр дууны ид шидээр аяны ядаргаагаа гаргадаг «Эрдэнэ засгийн унага» бол Монгол ардын уртын дууны нэг бөгөөд эр хүний хүчин зоригийг хөвчилж, амьдралын сайн

сайхныг бэлэгшээсэн энэхүү дуу «Тунгалаг Тамир» романд эхлэлээсээ төгсгөл хүртлээ тууштай өгүүлэгдсэн байдаг. Нөгөө талаар, «Тунгалаг Тамир» романд илэрсэн газрын нэр, амьдрал ахуйд илрэх эд хэрэглэл, хэрэг учрын нэрийдэл, мал ахуй, амьтан араатны дуудлага шинж, тэрчлэн зохиолын баатруудын нэр гэх зэрэг аль олон төрөл зүйлийн талаарх дүрслэл, мэдээлэл нь нэгэн соёлын системийг бий болгож байгаагаараа бүхэлдээ тус зохиолыг судлаж болох салбар судалгааны хандлагыг өөртөө агуулахад хүрсэн гэж үзэж болно.

Харин уг романыг хятад хэлэнд буулгасан нь Монгол үндэстнийхээ зан заншил, ёс суртахууныг амьдралын явцдаа ойлгож суралцсаны хүчинд хоёр өөр соёлын харилцан адилгүй шинжүүдийг оновчтой үг хэллэг, нэр томъёо, зан үйлүүдээр дамжуулан илэрхийлж чадсанаараа «Тунгалаг Тамир» романы хэл хэллэг, утга агуулгыг дээд зэргийн мэдрэмжээр амьдлаг орчуулж, Өвөрмонголын, улмаар Дундад улсын түг түмэн уншигчдад амжилттай хүргэж чаджээ.

Орчуулагчийн ажил бол зөвхөн үг хэллэгийг махчилан орчуулж, цэг тэмдэг, язгуур дагаварыг зөв оновчтой хэрэглэвэл болчихдог ажил биш юм. Орчуулга нь соёл хоорондын харилцаанд ямар нэгэн өө сөв гаргалгүй нэг үндэстний соёл боловсрол, амьдрал тэмцлийн үзэл санааны хандлагыг язгуур чанараар нь өөр бусад үндэстний уншигч түмэнд хүргэх явдал бөгөөд энэ нь орчуулагчийн ажлын утга учир мөртлөө чухал чанар мөн [Ли Зай Ду, Мэн Жу Юан 2005: 591]. Орчуулгын явц дунд соёлын хоёр өөр тогтолцооны хоорондох зөрөө үүсэхээс гадна тэдгээрийг тэмдэглэн илэрхийлдэг хэл ярианы зөрөө, үг хэллэгийн дэс дарааны хувьд ч ялгаа зөрөө үүсдэг юм.

Орчуулагчаас «Тунгалаг Тамир» романыг орчуулахдаа хэл хэллэг, зан заншил, амьдрал ахуй, соёл боловсролын харилцаан дахь саад бэрхшээлийг нэгд нэгэнгүй даван туулж, Өвөрмонголын уран зохиолын Хятад хэлний хэрэглээг ч шинэ шатанд ахиулсан төдийгүй Дундад улсын монгол зохиолчдын хятадаар илэрхийлэх явцад хүндрэл учруулж буй хэл хэллэг, соёл боловсролын асуудлуудыг дөхөм дөт, амьдлаг дүрслэх арга замыг баяжуулж байгаагаараа чухал ач холбогдолтой юм.

Монгол улсын алдарт зохиолч, соёлын гавьяат зүтгэлтэн, төрийн хошой шагналт

Ч. Лодойдамба гуай Тамирын голын хөвөөндөө үе үеийн турш амьдарсан малчин түмний амьдрал ахуйд суурилж, Тамирын хөндийд, түүгээр дамжуулан нийт Монгол улс даяарт болж буй нийгэм-улс төр, ахуй амьдралын хувьсалт өөрчлөлтийг илэрхийлэн өгүүлж, улс төр, нийгэм амьдралын зөрчил мөргөлдөөнийг нэгд нэгэнгүй уран зохиолын дэг маягт урлагжуулан «Тунгалаг Тамир» романаа туурвин бүтээжээ.

«Тунгалаг Тамир» романд үндэстний шинж ба орон нутгийн онцлог шинжийг ил тод илрүүлэн гаргасан юм. Монголын уламжлалт сайн «эр»-ийн дүр ба өвөрмөц зан үйлүүд, Монгол үндэстний уламжлалт ёс заншлыг илрүүлэн гаргасан төдийгүй нүүдлийн соёл иргэншил, мал аж ахуйн амьдралаас урган гарсан олон хэвшмэл хэллэг, хэлц үг, ардын дуу, шүлэг, ерөөл магтаалыг багтаажээ. Босоо монголд хөрвүүлэгдэн хэвлэгдсэнээсээ гадна «Тунгалаг Тамир» роман эдүгээ нэгэнт гадаадын найман хэлээр орчуулагдахын хамт «Тунгалаг Тамир» гэсэн нэр бүхий гурван анги киног романы агуулгын дагуу найруулагдаж нийтийн хүртээл болсон билээ. Тус зохиол нь Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын уран зохиолын сурах бичигт сонгогдон орсон зэрэг мэдээ сэлтээс тус романы уран зохиолын хүрээнд болоод судалгаа шинжлэлд үзүүлсэн үнэ цэнэ буюу хувь нэмрийг зохих хэмжээгээр харуулна.

«Тунгалаг Тамир» роман Өвөрмонголын уншигчидтай анх золгосноосоо аваад өнөөдрийг хүртэл уншигчдын хүсэл сонирхлыг татаж, оюуны эрэлт хэрэгцээг хангасаар байна. Өвөрмонголчуудын дунд «Тунгалаг Тамир»-ын уншилт хийх, «Цахиур» Төмөрөөр бахархах сэтгэгдэл өнөөг хүртэл үргэлжилсээр байгаа юм. Нүүдлийн соёл иргэншил, бэлчээрийн мал аж ахуйгаас үүдэн тогтсон амьдралын соёл, онцлогт суурилж, уламжлалт зан заншлыг дэлгэн үзүүлээд мал аж ахуй, тал нутгийн энгүүн амьдралыг зураглан бичсэн болохоороо Өвөрмонголын уран зохиолын хөрсөнд ч удаж төдөлгүй дэлгэрэн тархаж, соёлын үр шимээ харамгүй түгээсээр уншигчдын сэтгэл зүрхэнд гүнээс гүн үндэслэжээ.

«Тунгалаг Тамир» романаас хойш Өвөрмонгол уран зохиолчдын түүхэн сэдэвт роман, «сайн эр»-ийн дүр төрхийг бишрэн

магтсан сэдэвтэй, шарын шашны нөлөө тусгалыг шүүмжлэн илчилсэн агуулга бүхий Өвөрмонголын нийгмийн амьдралын зөрчил мөргөлдөөн, чөлөөлөлтийн үеийн цаг төрийн сэдэв бүхий роман зохиолууд удаа дараагаар зохиогдон уншигчдын гар дээр хүрэх болжээ.

«Тунгалаг Тамир» роман нь Өвөрмонгол зохиолчдын бүтээн туурвихуйн сэтгэлгээг чөлөөлсөн төдийгүй Өвөрмонгол уншигчдын талархлыг хүлээсэн төдийгүй эрдэмтэн судлаачдын судалгааны ажлын үр дүнгээс ч үзсэн мөн адил, аль эсхүл «Тунгалаг Тамир» киноны урлагийн үнэ цэнийг тусгайлан авч үзсэн ч «Тунгалаг Тамир» роман нь Өвөрмонголын уран зохиолд бага бус хэмжээний нөлөө үзүүлж, Өвөрмонголын романы төрлийн бүтээл туурвиланд чухал түлхэц үзүүлжээ.

Нөгөө талаар, «Тунгалаг Тамир» романы 1984 онд хятад хэлэнд орчуулагдан хэвлэгдсэн явдал нь Дундад болон Монгол хоёр улсын соёлын солилцооны түвшинг бас нэгэн шатаар ахиулан урагшлуулж, Монгол уран зохиолын орчуулгын болон хэл зүйн бусад саад тотгорыг хэрхэн даван туулах үлгэр жишээ болж өгсөн төдийгүй орчуулгын онол, арга зүйн асуудалд ч багагүй хэмжээний ахиц дэвшлийг авчирсан гэж үзэж болно. Монгол үндэстний өвөрмөц онцлог бүхий зан заншил, ёс суртахуун, нүүдэл буудал, мал ахуй, хувцас засал, эд хэрэгсэлтэй холбогдох нэр томъёо, газар усны нэрийдэл, мал амьтдын дуудлага зэргийг жинхэнэ агуулгаар нь үзүүлсэнээр Монгол амьдралын баялаг сайхан, тухайн үеийн нийгэм нийтийн зөрчилдөөний хурц ширүүн байдлыг илчлэн тусгаж чаджээ.

Хураангуйлбал, соёлын харилцааны үзэл санааны үүднээс авч үзвэл «Тунгалаг Тамир» романы Өвөрмонгол дахь Хятад, Монгол хос хэвлэл нь цөм уншигчдын таашаалыг нэгэнт олж, Өвөрмонголын монгол, хятад хос хэлэн дэх зохион бүтээлт, улмаар Өвөрмонголын романы туурвилд гэгээн саруул ирээдүйг харуулж чадсанаараа чухал ач холбогдолтой юм. Монгол, хятад хос хэлний «Тунгалаг Тамир» роман нь Дундад болон Монгол хоёр орны соёлын солилцоонд зохих хувь нэмэр үзүүлсэн төдийгүй Монгол үндэстний нийгэм, амьдрал ахуй, нүүдэл соёлын өвөрмөц онцлогуудыг эерэгээр хүлээж авах үнэлэмжид чухал нөлөө үзүүлж чаджээ.

Литература

- Ван Мин.* Монгол улсын орчин үеийн уран зохиолын орчуулгын дундоршиж буй асуудлын тухай (Ч. Лодойдамбын «Тунгалаг Тамир» романы жишээн дээр) // Өвөрмонголын багшийн их сургуулийн нийгмийн шинжлэх ухааны эрдэм шинжилгээний сэтгүүл. 2010. № 39 (1). Х. 25–33.
- Вен Ин.* «Тунгалаг Тамир» романы Хятад орчуулгын ололт, амжилт // Баруун хойдын үндэстний их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 2013. Х. 43–47.
- Вен Ин.* «Тунгалаг Тамир»-ын соёлын бүтцийг шинжлэх нь // «Дундад улсын монгол судлал» сэтгүүл. 2005. 5 сар. Х. 16–21.
- Ли Зай Ду, Мэн Жу Юан.* Дундад улсын орчуулгын соёлын түүх. Бээжин: Бээжингийн их сургуулийн хэвлэлийн хороо, 2005. 591 х.
- Лодойдамба Ч.* Тунгалаг Тамир. Хөххот: Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 1999. 482 х.
- Лодойдамба Ч.* Тунгалаг Тамир. УБ: Монгол улсын хэвлэлийн хороо, 1971. 453 х.
- Мандал А.* «Тунгалаг Тамир» дахь Итгэлтийн дүр // Өвөрмонголын үндэстний багшийн дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 1988. Х. 24–26.
- Хосбаяр Ч.* Лодойдамба ба түүний зохиол бүтээлийн тухай // Өвөрмонголын багшийн их сургуулийн докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, 2007. Х. 23.

References

- Lodoidamba Ch. *Tungalag tamir* [Transparent Tamir]. Hohhot, Inner Mongolia People's Publ. House, 1999, 482 p. (In Mong.).
- Van Min. *Mongol ulsyn orchin ueiin uran zohiolyn orchuulgyn dund orshizh buj asuudlyn tuhaj* (Ch. Lodoidambyn "Tungalag tamir" romany zhisheen deer") [On the issues of modern Mongolian literature (evidence from Ch. Lodoidamba's novel *Tungalag Tamir*)]. *Övörmongolyn bagshiin ih surguuliin niigmin shinzhljeh uhaany erdem shinzhilgeenij setgüül* [Scientific journal for social studies of Inner Mong. Pedagogical Univ.], 2010, No. 39 (1), pp. 25–33 (In Mong.).
- Lodoidamba Ch. *Tungalag tamir* [Transparent Tamir]. Ulaanbaatar, Mongolian Publ. House, 1971, 453 p. (In Mong.).
- Mandal A. "Tungalag tamir" dah' Itgeltiin dür [The image of Itgelt in the novel *Tungalag Tamir*]. *Övörmongolyn ündestnij bagshiin deed surguuliin erdem shinzhilgeenij setgüül* [Scientific journal of Inner Mong. National Pedagog. Institute], 1988, pp. 24–26 (In Mong.).

- Hosbayar. *Ch. Lodoidamba ba түүний зохиол бүтээлийн тухай* [About Ch. Lodoidamba and his compositions]. *Övörmongolyn bagshiin ih surguuliin doktoryn zereg gorilson neg sedevt бүтээл* [An abstract of the Ph.D. thesis. Inner Mong. Pedagog. University], 2007, 23 p. (In Mong.).
- Ven In. “*Tungalag tamir*” romany Hyatad orchuulgyn ololt, amzhilt [Merits of the Chinese translation of the novel *Tungalag Tamir*]. *Baruun hoidyn үндэстний ih surguuliin ердэм шинжилгэенii setgüül* [Scientific journal of North-Western National Univer.], 2013, pp. 43–47 (In Chinese).
- Ven In. “*Tungalag tamir*”-yn soyolyn бүтсииг шинзлэх n’ [Studying the cultural component of the novel *Tungalag Tamir*]. “Dundad ulsyn mongol sudlal” setgüül (*Mongol Studies of China journal*), 2005, iss. 5, pp. 16–21 (In Chinese).
- Li Zaj Du, Mjen Zhu Juan. *Dundad ulsyn orchuulgyn soyolyn түүh* [The history of translation studies in China]. Beijing, Beijing Univ. Press, 2005, 591 p. (In Chinese).

УДК 821.512.36

РОМАН «ПРОЗРАЧНЫЙ ТАМИР» И ЛИТЕРАТУРА ВНУТРЕННЕЙ МОНГОЛИИ: РОЛЬ И ВЛИЯНИЕ

(«Тунгалаг Тамир» романы Өвөрмонголын уран зохиолд үзүүлсэн нөлөө, ач холбогдол)

Хишигдэлгэрийн Хөхмандал¹

¹ аспирант, кафедра литературы и искусства, Монгольский государственный университет (Улан-Батор, Монголия). E-mail: 920321387@qq.com.

Аннотация: Роман «Прозрачный Тамир», написанный известным монгольским литературоведом Ч. Лодойдамбой, был удостоен двух государственных премий Монголии и является одним из лучших произведений автора. Также этот роман, признанный в Монголии лучшим романом XX в., занимает достойное место в кинематографе и пользуется необычайной популярностью среди читателей. Он вообрал в себя общественный строй, жизнь и чаяния монгольского народа, начиная с 1914 по 1921 гг. Автор делает попытку проанализировать значимость, влияние, место и роль романа в культурах Монголии и Китая. «Прозрачный Тамир» оказал заметное влияние на культурную жизнь Внутренней Монголии, что повлекло за собой бурное развитие литературы в данном регионе.

Ключевые слова: Роман «Прозрачный Тамир», литература Внутренней Монголии, роль и место.